

ХУРААНГУЙ

Энэхүү үнэлгээний тайлан нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын статистик, эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хэрэгжилт гэсэн 2 бүлэг, 4 дэд бүлэг бүхий дүгнэлт, зөвлөмжөөс бүрдэж байна.

Үнэлгээнд тоон болон чанарын судалгааны аргыг ашиглаж, мэдээллийг баримтын болон асуулгын аргаар цуглуулсан. Ингэхдээ ЭМСЯ-ны төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу тусгайлан боловсруулсан хүснэгтэн загвар, асуулгыг ашиглан, өөрсдөөр нь үнэлгээ хийлгэж, ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийлээ.

Үнэлгээнд 10 аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМСЯ-ны харьяа 12 байгууллага, нийт 22 байгууллага хамрагдсан.

Аймаг, нийслэлийн ЭМГ-ын үнэлгээг 4 зорилт бүхий 16 үйл ажиллагаа нь нэгдсэн дүнгээр авч үзвэл, 49.5% нь маш сайн болон сайн, 14.3% нь хангалтгүй, 36.4% нь огт хэрэгжээгүй байна.

Эрүүл мэндийн дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт 52.3% нь маш сайн болон сайн хэрэгжиж, 4.5% нь хангалтгүй, 29.5% нь огт хэрэгжээгүй байна.

Хувийн хэвшлийн удирдлагын болон дэвшилтэт технологийн ур чадвар, туршлага, ноу хауг нэвтрүүлж, ашиглах зорилтын хэрэгжилт 68.1% нь маш сайн болон сайн хэрэгжиж, 9.0% нь хангалтгүй, 22.7% нь огт хэрэгжээгүй байна.

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн бизнесийн зүй тогтлоор хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай үнийн тогтолцоо бүрдүүлэх зорилтын хэрэгжилт 40.9% нь маш сайн болон сайн хэрэгжиж, 15.9% нь хангалтгүй, 43.1% нь огт хэрэгжээгүй байна.

Төр, хувийн хэвшлийн салбарын харилцан ашигтай, урт хугацааны түншлэл бий болгох зорилтын хэрэгжилт 34.1% нь маш сайн болон сайн хэрэгжиж, 13.6% нь хангалтгүй, 52.3% нь огт хэрэгжээгүй байна.

Эрүүл мэндийн төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа нь төсөлд хамтран ажиллах, анхан шатны болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачааллаас хуваалцах, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, сургалт зохион байгуулах, хог хаягдал, халдвар хамгааллын талаар гэрээтэй ажиллах зэрэг үндсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжиж байна.

Мөн Олон улсын байгууллага болон бусад байгууллагатай сургалт, эмчилгээ, оношилгоо, дэвшилтэт технологи, барилга байгууламж барих, засвар үйлчилгээ хийлгэх, харуул хамгаалалтын чиглэлээр түншлэн ажиллаж байна.

Үнэлгээний тайлангаас харахад Дархан-Уул, Дорнод, Төв, Дундговь, Булган, НЭМГ, ЭХЭМҮТ-ийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаа бусад байгууллагаас харьцангуй сайн байна. Баян-Өлгий, Говьсүмбэр аймаг, ХӨСҮТ, ЭСҮТ-ийн тайлан хангалтгүй байна.

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хувийн хэвшлийн тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангах зорилтын хүрээнд төр хувийн хэвшлийн түншлэл, концессын тухай эрх зүйн тодорхой орчин бүрдсэн байна. Тухайлбал:

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого-2009 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын их хурлаар,
- Концессын тухай хууль-2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Улсын их хурлаар,
- Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам-Засгийн газрын 2010 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 177 тогтоолоор,
- Концессын зүйлийн зардал ашгийн тооцоо хийх аргачлал, Урьдчилан шалгаруулалтын жишиг баримт бичиг, уралдаант шалгаруулалтын жишиг баримт бичиг, Уралдаант шалгаруулалтын санал, үнэлэх журам-Төрийн өмчийн хорооны 2010 оны 153, 342 тоот тогтоолоор тус тус батлагдсан байна.

Энэхүү эрх зүйн орчны хүрээнд 2011 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар “Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого”, бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан байна.

Энэхүү баримт бичгийн гол зорилго нь эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх нь өрсөлдөөнийг дэмжиж эрүүл мэндийн дэд бүтэц (барилга байгууламж, тоног төхөөрөмж, ус дулаан хангамж гэх мэт) болон тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн нийт санхүүжилтэд хувийн хэвшлийн оролцоо, эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх юм.

Ингэснээр салбарын хязгаарлагдмал хөрөнгө нөөцийн зарцуулалт, үр дүн, үр ашгийг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэх сонирхлыг бий болгоход оршиж байна.

Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлд:

- Монгол улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчний үеийн дэвшилтэт технологи, өндөр өртөг бүхий тусламж үйлчилгээ,
- Их хэмжээний өртөг, хөрөнгө оруулалт шаардсан эмнэлгийн дэд бүтцийг бүтээн байгуулах, шинэчлэн сайжруулах, сэргээн засварлах үйл ажиллагаа,
- Эрүүл мэндийн анхан шатны болон НЭМ-ийн тусламж, үйлчилгээ
- Эрүүл мэндийн мэдээллийн технологийн зарим үйлчилгээ,
- Байгалийн гамшиг, гэнэтийн ослын үеийн тусламж, үйлчилгээнд ашиглах эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх,
- Олон улсын байгууллагын тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хадгалах, тээвэрлэх, түгээх,
- Эмийн зохистой хэрэглээний сургалт, сурталчилгаа, хэрэглээнд хяналт тавих үйл ажиллагаа хамаарч байна.

Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМСЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагууд болон эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагууд тэргүүлэх чиг үүрэгтэй оролцох юм.

2010 онд “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохицуулалт ба санхүүжилт болон Монгол улсын эрүүл мэндийн салбар дахь төр хувийн хэвшлийн түншлэл” судалгаа хийгдсэн байна.

Энэхүү судалгаа нь эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын суурь судалгаа юм.

Судалгаагаар “Эрүүл мэндийн салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэлд санхүүжилт, эмнэлгийн бүтцийг барих, засах, улсын эрүүл мэндийн хөтөлбөр үйлчилгээг удирдах зэрэг зохицуулалт, хяналтын үйл ажиллагаа шаардлагатай” гэсэн байна.

Мөн аутсорсингийн үйлчилгээ, эмнэлгийн болон нийгмийн тусламж, үйлчилгээ, эмнэлгийн био хог хаягдал, эмнэлгийн хангамж, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн дэд бүтэц, сургалт зэрэг чиглэлийг авч үзэх шаардлагатай гэсэн байна.¹ 2010 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар “Эрүүл мэндийн хувийн хэвшлийн салбарын өнөөгийн байдал” судалгаа хийсэн байна.

“Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого” 2011 оноос эхлэн хэрэгжиж, бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө 2015 онд дуусч байна.

¹ Хувийн хэвшлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохицуулалт ба санхүүжилт болон Монгол улсын эрүүл мэндийн салбар дахь төр хувийн хэвшлийн түншлэл судалгаа 2010 он, хуудас54-55

Иймд 3 жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг үнэлэн, 2016-2020 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулахад нотолгоо мэдээллээр хангах нь энэхүү ажлын үндэслэл болж байна.

Үнэлгээний зорилго: Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлэн, цаашдын стратегийг боловсруулахад нотолгоогоор хангах.

Үнэлгээний зорилт:

1. “Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх 2011-2015 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх
2. Үнэлгээний үр дүнд үндэслэн 2016-2020 оны дунд хугацааны стратеги төлөвлөлт хийх талаар зөвлөмж боловсруулах

Ач холбогдол:

- Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд үндэслэн, цаашдын стратегийн чиглэл, төлөвлөгөөг боловсруулахад баримт, нотолгоо болж байгаагаар ач холбогдолтой.

Үр дүн:

- “Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх 2011-2015 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн төгсгөлийн үнэлгээний үр дүнгийн тайлан, зөвлөмж бичигдсэн байна.

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ, МАТЕРИАЛ

Үнэлгээний аргачлал: Үнэлгээнд чанарын болон тоон судалгааны аргыг ашигласан.

Мэдээлэл цуглуулалт: Баримтын болон асуумжийн аргаар мэдээлэл цуглуулсан.

Баримтын аргаар дараах мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийлээ:

- Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын төслүүдийн бодлого, эрх зүйн баримт бичиг
- Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын төслүүдийн бүртгэл, мэдээлэл
- ЭМСЯ, ЭМСЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагууд, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан
- Эрүүл мэндийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлэлцүүлэг, уулзалт, семинарын тайлан, мэдээ

Мөн ЭМСЯ-ны төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу тусгайлан боловсруулсан хүснэгтэн загвар, асуулгыг ашиглан, өөрсдөөр нь үнэлгээ хийлгэж, ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийлээ

Хамрах хүрээ: ЭМСЯ, яамны харьяа эрүүл мэндийн байгууллагууд, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

Сонгосон бүлэг: Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын эдийн засагч, асуудал хариуцсан мэргэжилтнүүд

Мэдээлэл боловсруулалт: Баримтын болон ярилцлагаар цуглуулсан мэдээлэлд агуулгын (контент анализ) дүн шинжилгээ хийж, тоон мэдээлэлд энгийн статистик шинжилгээ хийлээ.

Ажиллах хүн хүчин: ЭМСЯ болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Судалгаа, төлөвлөлт, статистик мэдээллийн албаны асуудал хариуцсан мэргэжилтнүүд гүйцэтгэлээ. Хүснэгтэн мэдээллийн нэгтгэлийг СТСМА-ны мэргэжилтэн Б.Доржмягмар гүйцэтгэж, Л.Ширнэн дүн шинжилгээ хийн, үр дүнгийн тайлан бичлээ.

Мэдээлэл түгээх: Үр дүнгийн тайланг ЭМСЯ-ны бодлого боловсруулагч, түншлэгч талууд, эрүүл мэндийн байгууллага, хэрэглэгчдэд түгээнэ.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын статистик

Монгол улсын эрүүл мэндийн салбарт өнөөгийн байдлаар төр, хувийн хэвшлийн түншлэлд өрхийн эрүүл мэндийн төв, хувийн эмнэлэг, рашаан сувилал, эм ханган нийлүүлэх байгууллага болон олон улсын байгууллагууд тэргүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Монгол улсад 2014 оны эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр:

- 218 өрхийн эрүүл мэндийн төв.,
- 202 ортой хувийн эмнэлэг.,
- 969 үүдэн хувийн эмнэлэг.,
- 104 сувилал.,
- 160 эм ханган нийлүүлэх байгууллага.,
- 32 эмийн үйлдвэр.,
- 936 хувийн эмийн сан.,

нийт 2621 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага ажиллаж байгаа нь Монгол улсын хэмжээнд ажиллаж байгаа эрүүл мэндийн нийт байгууллагын 84.5%-ийг эзэлж байна.

2014 оны байдлаар эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудад 15598 ажиллах хүчин ажиллаж байгаа нь нийт эрүүл мэндийн ажиллах хүчний 36.0%-ийг эзэлж байна.


Хүснэгт 1. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллага – ажиллах хүчний динамик

Эрүүл мэндийн байгууллагууд	2009		2010		2011		2012		2013		2014	
	Байгууллагын тоо	Хүний нөөцийн тоо	Байгууллагын тоо	Хүний нөөцийн тоо	Байгууллагын тоо	Хүний нөөцийн тоо	Байгууллагын тоо	Хүний нөөцийн тоо	Байгууллагын тоо	Хүний нөөцийн тоо	Байгууллагын тоо	Хүний нөөцийн тоо
ӨЭМТ	226	2215	218	2265	219	2235	221	2377	228	2501	218	2588
Ортой эмнэлэг	160	1814	166	2115	171	2532	179	2806	197	3263	202	3938
Үүдэн эмнэлэг	922	1999	947	2199	1013	2310	851	2707	822	2572	969	3165
Аршаан, сувилал	13	616	16	515	67	1065	100	1326	71	1343	104	1516
Эм ханган нийлүүлэх	144	717	158	902	158	836	155	843	128	769	160	599
Эмийн үйлдвэр	57	601	41	356	42	423	42	353	42	300	32	80
Эмийн сан	636	2792	666	2884	703	3102	855	3544	789	3984	936	3712
Бүгд	2158	10754	2212	11236	2373	12503	2403	13956	2277	14732	2621	15598

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн нийт байгууллагын 37.0%-ыг үүдэн хувийн эмнэлэг, 35.7%-ыг хувийн эмийн сан эзэлж байна.

Нийт ажиллах хүчний 25.3%-ийг ортой эмнэлгийн ажилчид, 20.3%-ыг үүдэн эмнэлгийн ажилчид эзэлж байгаа нь олонхи болж байна.

Дүрслэл 1. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллага-ажиллах хүчин, 2014 он



Эрүүл мэндийн байгууллагын өсөлтөд үүдэн эмнэлэг, эмийн сангийн өсөлт шууд хамааралтай байна. Тухайлбал: эмийн сан 219-өөр өссөн байна.

Харин хувийн үүдэн эмнэлгийн хувьд арай өөр дүр зураг харагдаж байна. Тухайлбал: Үүдэн эмнэлэг 2009 оноос 2011 онд 91-ээр өссөнөө, 2012 онд 2011 оноос 162-оор буурсан байна.

3.2. Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хэрэгжилт

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хэмжээний цогц бодлогын “Хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй хөгжлийг хангах, бүх талын түншлэлийг хөхүүлэн дэмжих” чиг хандлагад тулгуурлан ЗГ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” батлагдан хэрэгжиж байна.

Эрүүл мэндийн салбарт энэхүү бодлогын хэрэгжилтийг ханган, 2011 онд “Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлого”, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн байна. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилт 2015 онд дуусч, цаашдын стратегийг боловсруулах хэрэгцээ, шаардлага тулгарсан тул энэхүү үнэлгээг хийлээ.

Үнэлгээг ЭМСЯ-ны төрийн нарийн бичгийн баталсан удирдамжийн дагуу хийлээ.

Үнэлгээнд:

- 21 аймгаас Сэлэнгэ, Өвөрхангай, Төв, Дархан-Уул, Дундговь, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Булган, Дорнод аймаг, нийт 10 аймаг,
- ЭМСЯ-ны харьяа 16 байгууллагаас Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Геронтологийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилал, Нийслэлийн эрүүл мэндийн газар, нийт 12 байгууллага, бүгд 22 байгууллага хамрагдлаа.

Увс аймаг тайлангаа ирүүлсэн боловч мэдээлэл авах боломжгүй байсан учир нэгдсэн дүгнэлтэд оруулаагүй болно.

Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь 4 зорилтын хүрээнд 29 үйл ажиллагааг төлөвлөсөнийг, үйл ажиллагааны агуулгаас нь шалтгаалан ЭМСЯ-ны хэрэгжүүлэх үйл ажиллагаа, аймаг, нийслэлийн ЭМГ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэж ангилан авч үзлээ.

Үнэлгээний аргачлалын дагуу тусгайлан боловсруулсан хүснэгтэн загварын дагуу байгууллагын удирдлага, эдийн засагч, асуудал хариуцсан мэргэжилтэн хамтран ярилцах замаар өөрсдөө үнэлгээ өгч, үнэлгээний дагуу хэрэгжилтийн тайлангаа ирүүлсэн болно.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ 5 баллын системээр, А-маш сайн хэрэгжиж байгаа, В-сайн хэрэгжиж байгаа, С-хэрэгжилт дунд зэрэг, D-хэрэгжилт муу, хангалтгүй, F-огт хэрэгжээгүй гэсэн үнэлгээ өгсөн.

Төлөвлөгөөнд тусгагдсан хариуцагч болон хамтрагч талуудаас хамааран 4 зорилтын хүрээнд ЭМСЯ нь 29 үйл ажиллагаа, аймаг, нийслэлийн ЭМГ нь 16 үйл ажиллагааны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн.

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ЭМСЯ-ны харьяа байгууллагууд хамаарал багатай, төлөвлөгөөнд нэр заан тусгагдаагүй учраас хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэхэд өрөөсгөл учраас 5 баллын системээр үнэлгээ өгөлгүй, зөвхөн бичмэл тайланд дүн шинжилгээ хийсэн болно.

Мөн бичмэл тайлангаас төлөвлөгөөний зорилт бүрийн хүрээнд гол санаа, агуулгыг дүгнэн, үйл ажиллагааны нотолгоо болгон, зарим жишээ, баримтыг шигтгээ болгон орууллаа.

Байгууллагуудын ирүүлсэн үнэлгээний тайлангаас харахад үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт руу чиглээгүй, бусад ажлыг хамааруулан тайлагнахыг оролдсон, тайлагнасан үйл ажиллагаа нь оновчтой бус, давхардсан санаа ихтэй, мөн огт хэрэгжээгүй, ямар нэг санаа, санаачилга гаргаагүй үйл ажиллагаа цөөнгүй байв.

Мөн нөгөө талаас үйл ажиллагааны төлөвлөгөө нь ихэвчлэн ЭМСЯ-аас хамааралтай, тайлагнахад ойлгомж муутай үйл ажиллагаа төлөвлөгдсөн байдал ажиглагдаж байгаа нь цаашдын төлөвлөгөөг боловсруулахад анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.


Хүснэгт 2. Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн бодлогын хэрэгжилтийн нэгдсэн үзүүлэлт (байгууллагаар)

№	Байгууллагын нэр	Үнэлгээ									
		А		В		С		D		F	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Төв аймгийн ЭМГ	2	12.0	7	44.0	-	-	-	-	7	44.0
2	Өвөрхангай аймгийн ЭМГ	6	38.0	6	38.0	-	-	-	-	4	24.0
3	Баян-Өлгий аймгийн ЭМГ	1	6.0	1	6.0	1	6.0	2	13.0	11	69.0
4	Дундговь аймгийн ЭМГ	3	19.0	7	44.0	6	38.0	-	-	-	-
5	Дорнод аймгийн ЭМГ	2	13.0	2	13.0	1	6.0	3	19.0	8	50.0
6	Говьсүмбэр аймгийн ЭМГ	-	-	-	-	-	-	-	-	16	100.0
7	Сэлэнгэ аймгийн ЭМГ	7	44.0	5	31.0	-	-	-	-	4	25.0
8	Дархан-Уул аймгийн ЭМГ	5	31.0	9	56.0	2	13.0	-	-	-	-
9	Булган аймгийн ЭМГ	2	13.0	8	50.0	4	25.0	2	13.0	-	-
10	Баянхонгор аймгийн ЭМГ	2	13.0	1	6.0	2	13.0	2	13.0	9	56.0
11	Нийслэлийн ЭМГ	6	38.0	5	31.0	2	13.0	-	-	3	19.0

Үнэлгээнээс харахад Сэлэнгэ, Өвөрхангай, Дархан-Уул, Дундговь, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн бодлогын хэрэгжилт харьцангуй сайн үнэлгээтэй байна. Харин Говьсүмбэр аймаг огт хэрэгжээгүй гэсэн бол Баянхонгор, Баян-Өлгий аймаг хэрэгжилт хангалтгүй байгаа гэж дүгнэжээ.

Байгууллагуудын ирүүлсэн бичмэл тайлангаас харахад Дархан-Уул, Төв, Дорнод, Дундговь, Булган, Өвөрхангай аймаг, Дундговь, ЭХЭМҮТ, УГТЭ-ийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагаа бусад байгууллагаасаа сайн, бодитой байсныг онцлон тэмдэглэж байна.

Дүрслэл 2. аймаг, нийслэлийн эмг-ын Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн бодлогын хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ



Үнэлгээнд хамрагдсан аймаг, нийслэлийн ЭМГ-ын 49.5% нь хэрэгжилт хангалттай сайн, 8.0% нь дунд зэрэг, 6.3% хангалтгүй муу, 36.4% нь огт хэрэгжээгүй гэж үнэлсэн байна. 4 зорилтоор авч үзвэл, түншлэх замаар


тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн удирдлагын дэвшилтэт технологийн ур чадвар, туршлага, ноу хауг нэвтрүүлж ашиглах зорилт хамгийн сайн хэрэгжсэн, төр, хувийн хэвшлийн салбарын харилцан ашигтай, урт хугацааны түншлэлийг бий болгох зорилт хамгийн муу хэрэгжилттэй байна.

3.2.1. Эрүүл мэндийн дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа

Дээрх зорилтын хүрээнд:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой байдлын үнэлгээ.,
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой бүрдлийг тогтмол хянан зохицуулах механизм.,
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны оролдлогуудыг үнэлэх, сайжруулах, нэвтрүүлэн турших.,
- Уралдаант шалгаруулалтын үндсэн дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувь хүн, хувийн хэвшлийг сонгох ажлыг зохион байгуулах гэсэн үйл ажиллагааг авч үзлээ.

Дүрслэл 3. Эрүүл мэндийн дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт (тоогоор)



Эрүүл мэндийн дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааг нэгтгэн, хувиар авч үзвэл 20.5% нь маш сайн, 31.8% нь сайн, 13.6% нь дунд зэрэг, 4.5% нь хангалтгүй, муу хэрэгжсэн, 29.5% нь огт хэрэгжээгүй байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой байдлын үнэлгээ, үр дүн:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төрийн ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой байдлын үнэлгээг аймаг, нийслэлийн ЭМГ, нийт 11 байгууллагын 1 нь маш сайн, 5 нь сайн, 2 нь дунд, 1 нь хангалтгүй муу, 2 нь огт хэрэгжээгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.

Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газар нь төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой байдлын үнэлгээг:

- Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо.,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг сонгон шалгаруулахдаа.,
- Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанарт аудитын үнэлгээ хийхдээ.,
- Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудыг магадлан итгэмжлэх болон жилийн үйл ажиллагааг дүгнэхдээ тус тус зохистой байдлын үнэлгээ хийдэг байна.

Мөн аймгийн Эрүүл мэндийн газрууд нь тусгай зөвшөөрлийн комиссын даргын баталсан тушаалаар эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудад жил бүр төлөвлөгөөт хяналт хийдэг байна.

Тухайлбал: Дархан-Уул, Дундговь аймаг нь энэхүү зорилтын хүрээнд төр, эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагыг тарифын ялгаваргүйгээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр санхүүжүүлж байгаа байдлыг үнэлэхэд, тарифийн ялгаваргүй санхүүжиж байсан байна. Мөн Сэлэнгэ аймаг төлөвлөгөөт хяналт хийснээ тайлагнасан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой бүрдлийг тогтмол хянан зохицуулах механизм:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой бүрдлийг тогтмол хянан зохицуулах механизм бүрдүүлэх талаар аймаг, нийслэлийн ЭМГ-ын 3 нь “маш сайн”, 3 нь “сайн”, 1 нь “дунд”, 4 нь “огт хэрэгжээгүй” гэсэн үнэлгээ өгсөн байна.

Аймаг, Нийслэлд эрүүл мэндийн байгууллагад Засаг даргын захирамжаар батлагдсан, тусгай зөвшөөрөл олгох комисс ажилладаг тогтолцоотой байна.

Энэхүү комисс нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын зохистой бүрдлийг хянахдаа эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тэргүүлэх чиглэл, бодлого, шийдвэртэй тусламж, үйлчилгээ нь нийцсэн эсэх, хүний нөөцийн мэргэшсэн байдал, тусламж, үйлчилгээнд оруулж буй хувь нэмэр, ачаалал хуваалцаж байгаа зэргийг харгалзан үздэг байна.

***Шигтгээ 1:** Жилдээ нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 10.8-13.8% нь хувийн ортой эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, нэгдсэн эмнэлгийн ачааллаас хөнгөлж байна.*

Дундговь аймгийн ЭМГ-ын тайлангаас

***Шигтгээ 2:** Жилдээ нийт үзлэгийн 12.0%, хэвтэн эмчлүүлэгчдийн 10.6%, ор хоногийн 11.4%-ийг хувийн ортой эмнэлэгт гүйцэтгэн, улсын эмнэлгийн ачааллаас үүрэлцэн, 165 ажлын байр бий болгосон.*

Өвөрхангай аймгийн ЭМГ-ын тайлангаас

Мөн комисс нь тусгай зөвшөөрөл авах талаар хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллагуудын хүсэлтийг хянан хэлэлцэж, зөвшөөрөл олгох, мөн хугацааг сунгах зэргээр тогтмол хэвшсэн үйл ажиллагаа явуулдаг байна.

НЭМГ-ын хувьд зохистой байдлын үнэлгээнд үндэслэн НЭМГ-ын даргын 2015 оны “Чиглэл батлах тухай” А/11 тушаалаар, алслагдсан байршилд хувийн хэвшлийн эмнэлэг байгуулан, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан нь оновчтой арга хэмжээ болсон байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зохистой бүрдлийг ихэвчлэн 3-5 хүний бүрэлдэхүүнтэй баг үнэлдэг байна. Мөн эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааны статистик үзүүлэлтийг сар бүр нэгтгэн дүгнэж, хувийн хэвшлийн эмнэлгүүд тусламж, үйлчилгээний ачааллаас хөнгөлж буй эсэхэд дүгнэлт өгдөг байна.

Зарим аймгийн Эрүүл мэндийн газар нь ортой хувийн эмнэлэгтэй түншлэлийн гэрээ байгуулж, гэрээний зохицуулах зөвлөл томилсон ба энэхүү зөвлөл нь хяналт үнэлгээ хийх чиг үүргийг хүлээдэг байна. Гэхдээ аймгуудад төр, хувийн хэвшлийн асуудал хариуцсан орон тооны мэргэжилтэн ажилладаггүй, бусад ажлын дайвар төдий байгаа нь хянан зохицуулах механизмын тогтвортой байдал хангагдсан, зорилт руу чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлдэг гэж үзэх боломжгүй болгож байна.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны оролдлогуудыг үнэлэх, сайжруулах, нэвтрүүлэн турших:

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны оролдлогуудыг үнэлэх, сайжруулах, нэвтрүүлэн турших талаар 3 байгууллага маш сайн, 2 нь сайн, 1 нь дунд, 1 нь муу, 4 нь огт хэрэгжээгүй гэсэн байна.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны оролдлогуудыг үнэлэх, сайжруулах, нэвтрүүлэн турших үйл ажиллагааны хүрээнд олон улсын болон төрийн бус байгууллагууд, холбоо, нийгэмлэгүүдтэй түншлэн, тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажилласан талаар түлхүү тайлагнасан байна.

Аймгаар авч үзвэл: Баянхонгор аймаг Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Олон нийтийн хөгжил төрийн бус байгууллага, Дундговь аймаг Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Дархан-Уул аймаг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Төв аймаг Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3-тэй хамтран ажилласанаа тайлагнасан байна.

***Шигтгээ 3:** Азийн Хөгжлийн Банкны ЭМСХХ-3 төслийн хүрээнд давтан болон эмнэл зүйн сургалт зохион байгуулахад 74.4 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн хамгийн сүүлийн үеийн оношилгоо, эмчилгээний эмнэл зүйн удирдамж, ном гарын авлагаар бүх мэргэжилтэнг хангасан.*

Дундговь аймгийн ЭМГ-ын тайлангаас

Энэхүү олон улсын байгууллагуудтай сургалт зохион байгуулах, эмчилгээ, оношилгооны гарын авлага, удирдамж, тоног төхөөрөмжөөр хангагдах, өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих, их засвар хийх зэрэг оюуны болон үл хөдлөх хөрөнгө оруулалтаар хангагдсан талаар дурдсан байна.

Шигтгээ 4: Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагатай хамтран эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр “Гал голомт” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Мөн Эм холбоотой хамтран эмзэг бүлгийн ахмад настнаа витаминжуулах аян жил бүр зохион байгуулдаг.

Баянхонгор аймгийн ЭМГ-ын тайлангаас

Мөн хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд нь аймгийн нэгдсэн эмнэлэгтэй, эмнэлгийн хог хаягдлыг устгах гэрээтэй ажилладаг байна.

НЭМГ-ын хувьд 2014 оноос эхлэн Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн хувийн хэвшлийн 7 байгууллагатай гэрээ хийн, хамтран ажиллаж эхэлсэн байна. Гэрээний хугацаанд 2 удаа үнэлгээ хийсэн ба Грандмед, Мон мэс эмнэлэг нь магадлан итгэмжлэгдээгүй учир хасагдсан байна.

ЭМСЯ-ны харьяа ортой төв эмнэлгүүдийн хувьд хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдтэй өвчтөн шилжүүлэх, нас барсан эмчлүүлэгчийн цогцсыг түр байршуулах зэргээр гэрээ хийж ажилладаг. Тухайлбал: ЭХЭМҮТ нь Интермед, Гурвангал эмнэлэгтэй хамтран ажиллаж, лавлагаа тусламж шаардлагатай хүүхдүүдийг тус эмнэлгүүдээс шилжүүлэн авч эмчилсэн байна.

Мөн лавлагаа төвүүд нь хувийн хэвшлийн анагаахын сургууль, мэргэжлийн нийгэмлэг, холбоотой сургалтын чиглэлээр хамтран ажилладаг байна.

Үнэлгээний тайлан дотор хамтын ажиллагааг үнэлсэн, сайжруулан туршсан гэсэн тайлан, мэдээ байхгүй байгаа нь энэ чиглэлээр хийсэн үйл ажиллагаа хангалтгүй, огт хэрэгжээгүйг харуулж байна.

Уралдаант шалгаруулалтын үндсэн дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувь хүн, хувийн хэвшлийг сонгох ажлыг зохион байгуулах:

Уралдаант шалгаруулалтын үндсэн дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувь хүн, хувийн хэвшлийг сонгох ажлыг зохион байгуулах талаар 2 байгууллага “маш сайн”, 4 нь “сайн”, 2 нь “дунд”, 3 нь “огт хэрэгжээгүй” гэсэн үнэлгээ өгсөн байна.

Уралдаант шалгаруулалтын үндсэн дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувь хүн, хувийн хэвшлийг сонгоходоо ихэвчлэн дэмжих үйлчилгээний чиглэлээр.,

Тухайлбал: Хэвтэн эмчлүүлэгчдийг хоолоор хангах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, ажилчдын цайны газар ажиллуулах, жирэмсэн эхчүүдийг амраан сувилах, эх хүүхдийн хоол тэжээлийн сувилал, харуул хамгаалалтын үйл ажиллагаанд хувь хүн, төрийн бус байгууллага, эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагыг сонгон шалгаруулсан байна.

Шигтгээ 5: Уламжлалт анагаах ухааны төвд хэвтэн эмчлүүлэгчдийг хоолоор хангах үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн байгууллагыг сонгон шалгаруулж, Мөнхдэлгэр ХХК-аар гүйцэтгүүлэн, жил бүр гэрээнд үнэлгээ өгч хамтран ажиллаж байна.

Дундговь аймгийн ЭМГ-ын тайлангаас

Шигтгээ 6: ЭМГ, нэгдсэн эмнэлгийн ажилчдын цайны газрын сонгон шалгаруулалт хийж, ЭМГ-ын цайны газарт хувь иргэний, НЭ-ийн цайны газарт Гозоорой ХХК шалгаран, гэрээ хийн ажиллаж байна.

Дархан-Уул аймгийн ЭМГ-ын тайлангаас

Шигтгээ 7: 2011 оноос төр, хувийн хэвшлийн 54 байгууллагатай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажиллаж байна. Тухайлбал Эрүүл идэвхитэй амьдрал клуб, ДЗОУБ-тай хамтран хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтууд болон архи, тамхины хэрэглээ бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Булган аймгийн ЭМГ-ын тайлангаас

Зарим аймгууд тайландаа уралдаант шалгаруулалтын үндсэн дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагаанд голлох байр суурийг өрхийн эрүүл мэндийн төв эзэлж байгааг хэдий ч уралдаант шалгаруулалт хийх боломжгүй гэдгийг дурдсан байна.

Бүлгийн товч дүгнэлт:

Эрүүл мэндийн дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилтийг хувиар авч үзвэл, 52.3% нь маш сайн болон сайн хэрэгжиж, 18.1% нь хангалтгүй, 29.5% нь огт хэрэгжээгүй байна.

Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохистой байдлын үнэлгээг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь тусгай зөвшөөрөл олгох, ЭМД-ын сангаас санхүүжилтийн сонгон шалгаруулалт хийх, жилийн үйл ажиллагааг үнэлэхдээ, тухайн ажлын хавсрага байдлаар гүйцэтгэж байна.

Зохистой бүрдлийг хянан зохицуулах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл олгох комисс, ЭМГ-ын мэргэжилтнүүд мөн л ажлын дайвар байдлаар хийж байна. Үнэлгээ хийхдээ ихэвчлэн, хүний нөөцийн мэргэисэн байдал, тусламж, үйлчилгээнд оруулж буй хувь нэмэр, ачаалал хуваалцаж байгаа байдлыг харгалздаг байна.

НЭМГ нь зохистой бүрдлийн хянан зохицуулах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, алслагдсан байришлд эмнэлэг байгуулах эрх зүйн орчин бүрдүүлсэн давуу талтай байна.

Байгууллагууд нь энэ зорилтын хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаа ихэвчлэн тайлагнасан байна.

Төр, хувийн хэвшлийн байгууллагууд хог хаягдал, өөрийн эмнэлэгт хийгдэхгүй байгаа тусламж, үйлчилгээ болон сургалт, тоног төхөөрөмжийн хангамж зэрэг үйл ажиллагааны чиглэлээр хамтран түншилсэн байна.


Төрийн байгууллага нь цайны газар, сувилал, харуул хамгаалалтыг гэрээгээр гүйцэтгэх хувь хүн, хувийн хэвшлийг уралдаант шалгаруулалтаар сонгон ажиллуулж байна.

3.2.2 Түншлэх замаар тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн удирдлагын болон дэвшилтэт технологийн ур чадвар, туршлага, ноу хауг нэвтрүүлж ашиглах үйл ажиллагаа

Дээрх зорилтын хүрээнд:

- Олон улсын болон орон нутгийн туршлагыг үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд удирдлагат өрсөлдөөн, ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэлбэрүүдийг үе шаттай нэвтрүүлэх.,
- Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах, батлуулах.,
- Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.,
- Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээг түншлэлийн арга хэлбэрээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах гэсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжсэн байна.

Дүрслэл 4. хувийн хэвшлийн удирдлагын болон дэвшилтэт технологийн ур чадвар, туршлага, ноу хауг нэвтрүүлж ашиглах үйл ажиллагааны хэрэгжилт



Түншлэх замаар тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн удирдлагын болон дэвшилтэт технологийн ур чадвар, туршлага, ноу хауг нэвтрүүлж, ашиглах зорилтын хэрэгжилтийг хувиар авч үзвэл, 38.6% нь маш сайн, 29.5% нь сайн, 4.5% нь дунд зэрэг, 4.5% нь хангалтгүй, муу хэрэгжсэн, 22.7% нь огт хэрэгжээгүй байна.

Үзүүлэлт бүрээр авч үзвэл, улсын төсөв, ЭМД-ын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх ЭМБ-ыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулдаг үйл ажиллагаа хамгийн сайн хэрэгжиж байна.

Харин эмнэлгийн тусламж, үйлчилгээнд удирдлагат өрсөлдөөн, ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагаа хамгийн хангалтгүй байна.

Олон улсын болон орон нутгийн туршлагыг үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд удирдлагат өрсөлдөөн, ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэлбэрүүдийг үе шаттай нэвтрүүлэх:

Олон улсын болон орон нутгийн туршлагыг үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд удирдлагат өрсөлдөөн, ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэлбэрүүдийг үе шаттай нэвтрүүлэх талаар 1 байгууллага маш сайн, 4 нь сайн, 1 нь дунд, 1 нь хангалтгүй муу, 4 нь огт хэрэгжээгүй гэж үнэлжээ.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрууд нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Төр, хувийн хэвшлийн түншлэл”-ийн гэрээ байгуулан, эмзэг бүлгийн хүн амыг хэвтүүлэн эмчлэх, хөнгөлттэй үнээр үйлчлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, дэвшилтэт технологийг хамтран ашиглах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх эмнэлгийн орны хүлээгдэл, ачааллыг бууруулах зэргээр хамтран ажилладаг байна.

Шигтгээ 8: Хувийн эмнэлэгтэй гэрээ байгуулан 87 хүнийг үнэ төлбөргүй хэвтүүлэн эмчлүүлж, 1055 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэсэн.

Дархан-Уул аймгийн ЭМГ-ын тайлангаас

Мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд төрийн бус байгууллагын оролцоог хангахын тулд эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр төслийн нээлттэй уралдаан зарлан хэрэгжүүлэх,

клуб байгуулах, өндөр хөгжилтэй гадаад орны эмч нартай хамтран ажиллаж, олон улсын туршлагаас суралцдаг зэрэг сайн туршлагууд байна.

Шигтгээ 9: Бэйст-Дент хувийн эмнэлэгтэй гэрээ байгуулан, 5 сумын 650 хүүхдийг эрүүлжүүлэн, Мөн Германы хил хязгааргүй нийгэмлэгийн нүүр ам судлалын эмч нартай 860 иргэнд үнэ төлбөргүй урьдчилан сэргийлэх үзлэг хийж, 360 хүнийг эмчлэн, шүдний кабинетыг тоног төхөөрөмжөөс хангасан

Булган аймгийн ЭМГ-ын тайлангаас

Шигтгээ 10: Залуу эмч нарын клубын санаачилгаар Америкийн болон Монголын мэс заслын эмч нарын нийгэмлэгтэй хамтран хэвлийн хөндийн дурангийн мэс засал хийж, эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн.

Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын тайлангаас

Шигтгээ 11: Эх хүүхдийн хоол тэжээлийн клиник сувилал ажиллуулах аймгийн ИТХ –ын шийдвэр гарч, сонгон шалгаруулалтаар Чинмэнд эмнэлэг шалгарч, 116 жирэмсэн эх, 78 нөхөн үржихүйн насны эмэгтэй, 308 хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Мөн 4 шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулан, 12903 хүүхдийн 2947 хүүхдийн шүдийг эрүүлжүүлсэн.

Өвөрхангай аймгийн ЭМГ-ын тайлангаас

Зарим аймаг тайландаа өрхийн эрүүл мэндийн төвөөр эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг гэрээгээр үзүүлж байгаагаа тайлагнасан байна.

Мөн ортой хувийн хэвшлийн эмнэлгүүд нь аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хог хаягдал, ариутгалын гэрээ байгуулан ажилладаг бол нэгдсэн эмнэлэг нь харуул хамгаалалтыг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлдэг байна.

ЭМСЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагууд нь тусламж, үйлчилгээний онцлогтой уялдан, өөр, өөрийн чиглэлээр олон улсын болон, төр, хувийн хэвшлийн байгууллагатай өргөн хүрээнд хамтын ажиллагааг өрнүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

- ЭХЭМҮТ нь Тайваны Ноордофф байгууллага, Японы зүрх хамгаалах төсөл, БНСУ-ын Сөүл төсөл, Японы сэтэрхий уруул, тагнайн нийгэмлэг, Тайваны үндэсний их сургууль, Туркийн Хажетэли их сургуультай тус бүр 5 жилийн, БНСУ-ын Вонгуаны их сургуультай 3 жилийн, АНУ-ын Самаритан Пурс төсөлтэй 2 жилийн, Францын Аксион Монгол нийгэмлэгтэй 1 жилийн гэрээ, санамж бичиг байгуулан хамтран ажилласан байна. Энэхүү гэрээ, санамж бичгийн хүрээнд оношилгоо, эмчилгээ хийлгэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургалтад хамруулах, хөдөө орон нутагт тухайн олон улсын байгууллагатай хамтран үзлэг оношилгоо, эмчилгээ хийх, тодорхой хэмжээний хөрөнгө, хандив туслалцаа авах, тоног төхөөрөмжөөр хангагдах зэргээр хамтын ажиллагааг өрнүүлсэн байна.
- ЦССҮТ нь улсын болон хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийг аюулгүй цус, цусан бүтээгдэхүүнээр хангахын тулд эмнэлгүүдтэй 1 жилийн гэрээ байгуулан, цус, цусан бүтээгдэхүүн нийлүүлдэг ба 2014 онд 381.46 литр бүтээгдэхүүнээр хангасан байна. Хүн амд эрүүл мэндийн болон донорын талаарх мэдлэгийг сайжруулах мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх чиглэлээр телевизүүд, Монос групп, Сүү хувьцаат компани, JCI, Green City, Unipress зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, цус бэлэглэх, донорын тоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.
- УГТЭ нь Люксембургийн их гүнт улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Зүрх судасны төв, Эх нярайн эрүүл мэнд ба Цахим эрүүл мэндийн өргөжилт төсөл хэрэгжиж, алсын зайн оношилгоо, эмчилгээ хийх, сургалт зохион байгуулах зэргээр хамтран ажилласнаа тайлагнасан байна.

Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах.,

Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах, талаар 6 байгууллага маш сайн, 3 нь сайн, 2 нь огт хэрэгжээгүй гэсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Улсын төсөв болон даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журам”, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 200 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 418 тоот “Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалт зохион байгуулах, журам батлах тухай” тушаалууд эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

Мөн 2015 оны ЭМС-ын сайдын 131 дугаар тушаалаар батлагдсан, шинэчлэн боловсруулан, ерөнхий болон өвөрмөц үзүүлэлт бүхий шалгуур үзүүлэлт бүхий аргачлал, заавар нь сонгон шалгаруулалтын шинэ эрх зүйн орчин болж байна.

НЭМГ нь 2020 оны Улаанбаатар хотын хүн амын тооцоог үндэслэн, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах орны хэрэгцээг тооцоолон, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж, үйлчилгээний төрлийн санал боловсруулан ЭМСЯ-ны СБТГ-т албан тоотоор хүргүүлсэнээ тайлагнасан байна.

ЭМСЯ-ны харьяа байгууллагууд нь Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн тодорхой заалтуудад үндэслэн, Нийгмийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ, амбулаторын эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээ, нөхөн сэргээх эмчилгээ, өндөр өртөгтэй тусламж үйлчилгээндээ даатгалын сангаас санхүүжилт авдагаа тайлагнасан байна.

Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах:

Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах талаар 8 байгууллага “маш сайн”, 2 нь “сайн”, 1 нь “дунд” гэж үнэлжээ.

Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах 9-11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, комисс томилогдон, сонгон шалгаруулалт хийдэг байна.

Комисс нь батлагдсан шалгуурын дагуу хувийн ортой эмнэлгүүдийн үйл ажиллагаанд жил бүр үнэлгээ, сонгон шалгаруулалт хийж, тусгай зөвшөөрлийн комиссын хуралдаанд хэлэлцүүлэн, шаардлага хангасан материалыг бүрдүүлэн, ЭМСЯ-д уламжлан, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах асуудлыг шийдвэрлүүлдэг байна.

Мөн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын газар, хэлтэс хамтран, эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнийн жороор үйлчлэх эмийн сангуудыг сонгон шалгаруулах ажлын хэсэг, комисс тухай бүр томилон ажиллуудаг байна.

Сонгон шалгаруулах комисс нь тухайн ондоо аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдан, сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг байна. 2015 оны хувьд ЭМСС-ын 2015 оны 04 сарын 07-ны өдрийн “Сонгон шалгаруулалтын аргачлал батлах тухай” 131 дугаар тушаалын дагуу орон нутагт комисс томилогдон ажилласан байна. Үнэлгээнд хамрагдсан аймгууд сонгон шалгууралт хийсэн мэдээ, тайлангаа дэлгэрэнгүйгээр хүргүүлсэн байна.

***Шигтгээ 12:** Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнийн жороор үйлчлэх эмийн сангийн сонгон шалгаруулалтыг комисс хийж, НДГ-т шийдвэрийг хүргүүлснээр эмийн сангууд хөнгөлөлттэй жороор үйлчлэх эрхээ авдаг. 2015 оны эхний хагас жилийн байдлаар 18047 хүнд үйлчилж, 168,805,700.0 төгрөгний эмийн үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллан, сонгон шалгууралт хийсэн.*

Төв аймгийн ЭМГ-ын тайлангаас

Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээг түншлэлийн арга хэлбэрээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах:

Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээг түншлэлийн арга хэлбэрээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангах талаар 2 байгууллага “маш сайн”, 4 нь “сайн”, 1 нь “дунд”, 1 нь “муу”, 3 нь “огт хэрэгжээгүй” гэсэн байна.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь Монгол улсын Засгийн газрын 2011 оны 364 дугаар тогтоолоор батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”, 2013 оны ЭМ-ийн сайдын 266 дугаар тушаал “Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хийх гүйцэтгэлийн гэрээний үлгэрчилсэн загвар”, “Гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт” зэрэг эрх зүйн орчны хэрэгжилтийг ханган ажилладаг.

Гэхдээ өрхийн эрүүл мэндийн төвийг уралдаант шалгаруулалтаар сонгох боломжгүй, одоо ажиллаж байгаа өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар гурвалсан гэрээ (аймгийн засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга) хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх байдлаар үйл ажиллагаа хэрэгжиж байна.

Гүйцэтгэлийн гэрээг аймгийн Засаг даргын захирамжаар, өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг дүгнэх журмын дагуу, тодорхой шалгуураар үнэлж, гэрээгээ жилд 1-2 удаа дүгнэдэг. “Гэрээний биелэлт ихэвчлэн “хангалттай” гэсэн үнэлгээ авдаг байна.

Шигтгээ 13: Дархан –Уул аймагт ажиллаж байгаа 5 өрхийн эрүүл мэндийн төвтэй гурвалсан гэрээг жил бүрийн 1 сард байгуулж, жилд 1-2 удаа гүйцэтгэлийг үнэлдэг. Үнэлгээний ажлын хэсэг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр засаг даргын захирамжаар томилогдсон. Гэрээний биелэлтийн хувь 69.0-91.1%-тай байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны тайланг Нээлттэй хаалганы өдрөөр хүн амд тайлагнаж байна.

Дархан-Уул аймгийн ЭМГ-ын тайлангаас

НЭМГ-ын хувьд өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэн, зөвлөмж өгч, гэрээгээ бүрэн хангалттай биелүүлсэн төвийг урамшуулан ажиллаж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь гэрээгээ дүгнүүлэхдээ зориулалтын байр, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангах, эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургалтад хамруулах, өндөр хөгжилтэй орны туршлагаас суралцуулах, нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг гаргадаг байна.

Бүлгийн дүгнэлт:

Хувийн хэвшлийн удирдлагын болон дэвшилтэт технологийн ур чадвар, туршилага, ноу хауг нэвтрүүлж, ашиглах зорилтын хэрэгжилтийг хувиар авч үзвэл, 68.1% нь маш сайн болон сайн, 9.2% нь хангалтгүй, 22.7 % нь огт хэрэгжээгүй байна.

Энэ зорилтын хүрээнд олон улсын болон орон нутгийн туршилагыг үндэслэн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ ихэвчлэн хувийн ортой эмнэлэгт эмзэг бүлгийн иргэдийг хөнгөлөлттэй үнээр хэвтүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, ачаалал бууруулах, гэрээт харуул ажиллуулах зэргээр хамтран ажилладаг байна.

Мөн олон улсын болон төрийн бус байгууллагатай ихэвчлэн оношилгоо, эмчилгээ, сургалт, дэвшилтэт технологийн чиглэлээр хамтран санамж бичиг, түншлэлийн гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн хувийн хэвшлийн эмнэлгүүд нь нэгдсэн эмнэлэгтэй хог хаягдал, аруитгалын гэрээ байгуулан ажиллаж байна.

Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах, батлуулах үйл ажиллагаа хэрэгжин, тодорхой эрх зүйн орчин бүрдсэн ба батлагдсан эрх зүйн орчныг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагууд хэрэгжүүлж байна.

Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар зохион байгуулж, жил бүр засаг даргын захирамжаар батлагдсан комисс ажиллан, сонгон шалгаруулалт хийж байна.

Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй үнийн жороор үйлчлэх эмийн сангуудыг сонгон шалгаруулдаг байна.


Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээг түншлэлийн арга хэлбэрээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчин бүрдэж, гүйцэтгэлийн хэрэгжилтийг дүгнэж ажилладаг тогтсон тогтолцоо бүрдсэн байна. Гэрээний хэрэгжилт ихэвчлэн хангалттай сайн байдаг байна.

3.2.3 Хувийн хэвшлийн бизнесийн зүй тогтлоор хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, улмаар үр дүнтэй болон өрсөлдөх чадвартай үнийн тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагаа

Энэ үйл ажиллагааг:

- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах.,
- Хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх стратегитэй болох
- Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй эрүүл мэндийн байгууллагын талаарх цахим мэдээллийн санг шинэчлэн сайжруулж, бүртгэл мэдээллийг тогтмолжуулах.,
- Түншлэлийн талаар олон нийтэд хүргэх цахим мэдээллийн тогтолцоог бий болгож, тогтолмуулах гэсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн байна.

Дүрслэл 6. хувийн хэвшлийн бизнесийн зүй тогтлоор хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай үнийн тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт (хувиар)



Эрүүл мэндийн хувийн хэвшлийн бизнесийн зүй тогтлоор хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай үнийн тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хувиар авч үзвэл, 13.6% нь маш сайн, 29.5% нь сайн, 6.8% нь дунд зэрэг, 9.1% нь хангалтгүй, муу хэрэгжсэн, 40.9% нь огт хэрэгжээгүй байна.

Дээрх зорилтын хүрээнд үзүүлэлтээр авч үзвэл төр, хувийн хэвшлийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зөвлөлдөх уулзалт хэлэлцүүлэг хийдэг, түншлэлийн талаар мэдээлэл хүргэх цахим тогтолцоо цөөнгүй газар бий болсон зэрэг сайн тал харагдаж байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах:

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах талаар 2 байгууллага “маш сайн”, 2 нь “сайн”, 2 нь “дунд”, 5 нь “огт хэрэгжээгүй” гэсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрууд нь жил бүр удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулж, эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудыг урьж оролцуулдаг байна.

Зөвлөгөөнөөр эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчны шинэчлэл, эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын хүний нөөцийн хөгжил, үйл ажиллагааны ололт амжилт, тусламж, үйлчилгээний чанар, хяналт үнэлгээний тайлан, халдвар хамгааллын асуудал, статистик үзүүлэлтийн тайлан мэдээ болон нийтлэг алдаа дутагдал, цаашид анхаарах асуудал зэрэг өргөн хүрээний асуудлыг авч хэлэлцдэг байна.

Мөн хувийн үүдэн эмнэлгүүдийг нэгтгэж, нэг зохион байгуулалтад оруулах, хувийн хэвшилд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төр, засгийн шагналаар шагнуулах асуудлыг шийдвэрлэх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын бүсчилсэн чуулга уулзалт зохион байгуулах, үйл ажиллагаагаа хорших, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах зэрэг санал хэлэлцүүлгээс дэвшүүлсэн байна.

Аймгуудын тайлангаас харахад Төв, Дундговь, Дархан-Уул аймгийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын уулзалт амжилттай зохион байгуулагдсан байна.

Шигтгээ 13: 2015 онд Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулья” уриатай удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулсан.

Дундговь аймгийн ЭМГ-ын тайлангаас

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх стратегитэй болох:

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх стратегитэй болох талаар нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 1 нь маш сайн, 1 сайн, 1 нь дунд, 8 нь “огт хэрэгжээгүй” гэсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газар нь Аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөг Засаг даргын тамгын газар болон харьяа дээд байгууллагаар батлуулан хэрэгжүүлж байна.

Тус стратегийн үйл ажиллагааны зорилтын нэг бүлэгт Эрүүл мэндийн улсын ба хувийн салбарын зохистой харьцааг хадгалах, эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагыг хөгжүүлэх, хамтын ажиллагаа, түншлэлийн талаар тодорхой заалтууд оруулан хэрэгжүүлдэг байна. Гэхдээ хэрэгжилт нь хангалтгүй байгаа талаар дурдсан байна.

Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, ялангуяа ортой эмнэлгүүд байгууллага хөгжүүлэх стратеги төлөвлөгөөтэй ажилладаг ба энэ нь нөгөө талаас магадлан итгэмжлэлд ороход нэг шалгуур үзүүлэлт болдогтой холбоотой байна.

Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй эрүүл мэндийн байгууллагын талаарх цахим мэдээллийн санг шинэчлэн сайжруулж, бүртгэл мэдээллийг тогтмолжуулах.

Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй эрүүл мэндийн байгууллагын талаарх цахим мэдээллийн санг шинэчлэн сайжруулж, бүртгэл мэдээллийг тогтмолжуулах талаар нь 4 нь маш сайн, 4 сайн, 1 нь муу, 2 нь огт хэрэгжээгүй гэсэн байна.

Аймаг, нийслэлийн ЭМГ нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын эрүүл мэндийн үзүүлэлтийн сар, улирлын мэдээг онлайн програмаар авч, нэгтгэдэг байна.

Аймгийн ЭМГ нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын талаарх мэдээний санг эксел, ворд программ дээр файл үүсгэх хэлбэрээр хадгалан, шинээр нэмэгдсэн байгууллагын мэдээллийг нэмж бүртгэдэг. Хувийн хэвшилтэй холбоотой мэдээллийг ЭМГ-ын цахим сайтаар олон нийтэд хүргэдэг.

НЭМГ-ын хувьд Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газартай SHP файл суулгаж, ArcGS программ дээр эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээлэл, шилжилт хөдөлгөөн, байршлын зураглал оруулж, Google earth ашиглан вебд байршуулахаар ажиллаж байгаа давуу тал байна.

ЭМСЯ-ны харьяа байгууллагууд нь өвчлөлийн бүртгэл, мэдээлэл, санхүүгийн тайлан мэдээллийн программ хангамжуудыг хувийн хэвшлийн байгууллагаар, гэрээгээр гүйцэтгүүлэн, ашиглаж байна.

Түншлэлийн талаар олон нийтэд хүргэх цахим мэдээллийн тогтолцоог бий болгож, тогтолмуулах:

Түншлэлийн талаар олон нийтэд хүргэх цахим мэдээллийн тогтолцоог бий болгож, тогтолмуулах талаар нь 6 нь сайн, 2 нь хангалтгүй муу, 3 нь огт хэрэгжээгүй гэсэн байна. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын мэдээний булан ажиллуулан, мэдээллийг олон нийтэд хүргэж байна.

Тухайлбал: Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын хаяг, байршил, утас, тусламж, үйлчилгээний төрөл, хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, статистик үзүүлэлт зэргийг мэдээлдэг байна. Гэхдээ тайлангаас харахад хувийн хэвшлийн эрүүл мэндийн цахим мэдээний нэгдсэн сангийн бүрдэлт, тогтвортой байдал хангагдсан гэж үзэх боломж бага байна.

Шигтгээ 14: ЭМГ-ын цахим хуудсанд эрүүл мэндийн хувийн хэвшлийн эмнэлгүүдийн байршил, утас, үйл ажиллагааны чиглэлийн талаар мэдээний булан үүсгэн ажиллуулж байгаа.

Булган аймгийн ЭМГ-ын тайлангаас

НЭМГ-ын тайланд ЭМСХХ-4-ийн дэмжлэгтэйгээр ЭМСЯ нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын үндэсний хэмжээний нэгдсэн мэдээний сан бүрдүүлэхээр ажиллаж байгаа тухай дурдсан байна. ЭМСЯ-ны харьяа байгууллагууд нь цахим сайт, фэйсбүүк, интернет үйлчилгээ, телемедицины үйл ажиллагаагаа хувийн хэвшлийн байгууллагаар, гэрээгээр гүйцэтгүүлж байна.

Бүлгийн дүгнэлт:

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн бизнесийн зүй тогтлоор хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай үнийн тогтолцоо бүрдүүлэх зорилтын хэрэгжилтийг хувиар авч үзвэл, 43.1% нь маш сайн болон сайн, 15.9% нь хангалтгүй, 40.9% нь огт хэрэгжээгүй байна.

Аймгийн ЭМГ нь жил бүр удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөндөө эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын удирдлагын урин оролцуулдаг жишиг тогтсон байна.

Энэхүү уулзалт, хэлэлцүүлгээр эрх зүйн орчны шинэчлэл, хөгжлийн чиг хандлага, хамтын ажиллагаа, тусламж, үйлчилгээ, чанар, халдвар хамгаалал зэрэг өргөн хүрээний асуудлаар хэлэлцдэг байна.

Аймгийн эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөөний нэг бүлэгт хувийн хэвшлийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх “Эрүүл мэндийн улсын ба хувийн салбарын зохистой харьцааг хадгалах, эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагыг хөгжүүлэх, хамтын ажиллагаа, түншлэл”-ийн талаар тодорхой үйл ажиллагаа тусгагдсан байна. Гэхдээ хэрэгжилт нь хангалтгүй байгааг дурдсан байна.

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээг онлайн сар, улирлаар авч нэгтгэдэг байна.

НЭМГ нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээлэл, шилжилт хөдөлгөөн, байршлын зураглалыг Google earth ашиглан вебд байршуулахаар ажиллаж байгаа давуу тал байна

Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын талаарх цахим мэдээллийг өөрсдийн цахим хуудсанд булан нээж байршуулдаг байна.


Цахим хуудсаар ихэвчлэн хаяг, байршил, утас, тусламж, үйлчилгээний төрөл, хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, статистик үзүүлэлт зэргийг олон нийтэд мэдээлдэг байна.

3.2.4. Төр, хувийн хэвшлийн салбарын харилцан ашигтай, урт хугацааны түншлэлийг бий болгох үйл ажиллагааны хэрэгжилт

Энэхүү үйл ажиллагаа нь

- Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх түншлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх нэгдсэн ойлголтыг хамтрагч талуудад бий болгох арга хэмжээнүүдийг үе шаттай зохион байгуулах.,
- Эрүүл мэндийн салбарт хэрэгжих боломжтой түншлэлийн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.,
- Түншлэлийн төслийн зардал, үр ашгийн тооцоо хийх, төслийг хэрэгжүүлэх этгээдийг сонгох уралдаант шалгаруулалт болон гэрээний зохицуулалтыг холбогдох бодлого, журмын дагуу хэрэгжүүлэх.,
- Түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд гэрээний нөхцөлийг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгуулах гэсэн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжсэн байна.

Дүрслэл 8. төр, хувийн хэвшлийн салбарын харилцан ашигтай, урт хугацааны түншлэлийг бий болгох үйл ажиллагааны хэрэгжилт (тоогоор)



Төр, хувийн хэвшлийн салбарын харилцан ашигтай, урт хугацааны түншлэл бий болгох зорилтын хэрэгжилтийг хувиар авч үзвэл, 9.1% нь маш сайн, 25.0% нь сайн, 6.8% нь дунд зэрэг, 6.8% нь хангалтгүй, муу хэрэгжсэн, 52.3% нь огт хэрэгжээгүй байна.

Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх түншлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх нэгдсэн ойлголтыг хамтрагч талуудад бий болгох арга хэмжээнүүдийг үе шаттай зохион байгуулах талаар 2 байгууллага маш сайн, 2 нь сайн, 1 нь дунд зэрэг, 1 нь муу, 5 нь огт хэрэгжээгүй гэжээ.

Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх түншлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх нэгдсэн ойлголтыг хамтрагч талуудад бий болгох арга хэмжээнүүдийг үе шаттай зохион байгуулах талаар 2 байгууллага маш сайн, 2 нь сайн, 1 нь дунд зэрэг, 1 нь муу, 5 нь огт хэрэгжээгүй гэжээ.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар нь төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг сайжруулах чуулган, уулзалт, хэлэлцүүлэг хийх, цаг үеийн холбогдолтой харьяа дээд байгууллагын тушаал, шийдвэрийг танилцуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

Чуулган, уулзалт хэлэлцүүлэгт ихэвчлэн төр, хувийн хэвшлийн удирдах албан тушаалтнууд оролцон, мэдээлэл солилцон, цаашид хамтран ажиллах талаар зөвшилцдөг байна.

Тухайлбал: ЭМСС-ын 2015 оны 04 сарын 07-ны өдрийн “Сонгон шалгаруулалтын аргачлал батлах тухай” 131 дугаар тушаалыг танилцуулах, магадлан итгэмжлэлд хамруулах сэдвээр хувийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагатай уулзалт хийсэн талаар тайландаа дурдсан байна.

Шигтгээ 14: 2015 онд Эрүүл мэндийн засаглал ба төр хувийн хэвшлийн түншлэл сэдэвт удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулж, 65 удирдах ажилтан оролцсон. Зөвлөгөөнөөр нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, оношилгоо, эмчилгээний технологи, эх хүүхдийн тусламж, үйлчилгээ зэрэг олон асуудлыг авч хэлэлцсэн.

Дархан-Уул аймгийн ЭМГ-ын тайлангаас

НЭМГ нь хувийн хэвшлийн байгууллагууд, тухайлбал, Хувийн лабораториуд, шүд, эх барих эмэгтэйчүүд, сувилалын удидлага, эмч мэргэжилтэнтэй уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна.

ЭМСЯ-ны харьяа байгууллагууд нь хөдөө орон нутгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран сургалт зохион байгуулах, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг хийх, эмгэг анатомын хурал зохион байгуулах зэрэг ажил зохион байгуулдаг байна.

Мөн мэргэжлийн салбар, нийгэмлэг, холбоо, НУБ-ын ХАС, ДЭМБ, АШУШИС болон чиглэл чиглэлээрээ төрийн бус байгууллагатай хамтран уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсанаа тайлагнасан байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжих боломжтой түншлэлийн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлэх:

Эрүүл мэндийн салбарт хэрэгжих боломжтой түншлэлийн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлэх талаар 1 байгууллага маш сайн, 4 нь сайн, 1 нь дунд, 5 нь огт хэрэгжээгүй гэжээ.

Аймгууд нь дэд бүтэц, шинэ барилга барих, барилга, сан техникийн их засвар хийх, тоног төхөөрөмжөөр хангагдах, автопаркийн шинэчлэл хийх зэрэг санал, хүсэлт боловсруулан харьяа дээд байгууллагад хүргүүлдэгээ тайлагнасан байна.

Мөн олон улсын байгууллагад хандан хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх, эрүүл дэмжлэгт орчин бүрдүүлэх, эрүүл ажлын байр бий болгох зэрэг төслүүд боловсруулан, хамтарч ажилладаг байна.

Тухайлбал: Дархан-Уул аймагт “Аяга сүү” төсөл, Эрүүл хот, дүүрэг, сум баг бий болгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдах зөвлөлийн уулзалт, Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд зөвлөгөөн, багш шавийн уулзалт зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

НЭМГ нь Чингэлтэй дүүргийн ЭМТ-ийн нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн ажлыг концессын гэрээгээр бариулахаар холбогдох тооцоо, судалгааг гарган ЭМСЯ-нд хүргүүлсэн байна.

ЭМСЯ-ны харьяа байгууллагууд нь тусламж, үйлчилгээний чиглэлээр, оношилгооны эмчилгээний технологийг боловсронгуй болгох төсөл боловсруулан хэрэгжүүлдэг байна. Тухайлбал: УГТЭ нь 2015 онд эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлд “Абляци эмчилгээ шаардлагатай хэм алдагдлын эмчилгээний технологийг нэвтрүүлэх”, “Хүүхдийн зүрх”, “Титэм судасны цочмог хам шинжийн оношилгоо эмчилгээний технологийг боловсронгуй болгох төслүүд боловсруулан хүргүүлж дэмжигдсэн байна.

Түншлэлийн төслийн зардал, үр ашгийн тооцоо хийх, төслийг хэрэгжүүлэх этгээдийг сонгох уралдаант шалгаруулалт болон гэрээний зохицуулалтыг холбогдох бодлого, журмын дагуу хэрэгжүүлэх:

Түншлэлийн төслийн зардал, үр ашгийн тооцоо хийх, төслийг хэрэгжүүлэх этгээдийг сонгох уралдаант шалгаруулалт болон гэрээний зохицуулалтыг холбогдох бодлого, журмын дагуу хэрэгжүүлэх талаар 1 байгууллага маш сайн, 3 нь сайн, 1 байгууллага муу, 6 нь огт хэрэгжээгүй гэжээ.

Төрийн байгууллага нь энэ үйл ажиллагааны хүрээнд тендерийн баримт бичиг боловсруулан, эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн урилга, зар гарган, эм ханган нийлүүлэх байгууллагатай хамтран ажилладаг. Мөн их засвар үйлчилгээ хийлгэх, гэрээт харуул хамгаалалт авахдаа сонгон шалгаруулалт хийдгээ энэ бүлэгт дахин тайлагнасан байна.

НЭМГ нь 2012-2014 онд Шүд, эрүү нүүрний төвийн барилгын зургийн даалгавар, эдийн засгийн үндэслэл, тооцоог хийж, орон нутгийн концессын жагсаалтад оруулсан ба гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг НЗДТГазар хийж байгааг дурдсан байна.

Үнэлгээгээ ирүүлсэн байгууллагууд нь түншлэлийн төслийн зардал, үр ашгийн тооцоо хийх үйл ажиллагааны талаар тоо, баримт дурдаагүй байна.

Түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд гэрээний нөхцөлийг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгуулах :

Түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд гэрээний нөхцөлийг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаагаа 2 байгууллага сайн, 1 байгууллага дунд, 1 нь муу, 7 байгууллага огт хэрэгжээгүй гэж үнэлсэн байна.

Үнэлгээний тайлангаа ирүүлсэн байгууллагууд түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд гэрээний нөхцөлийг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгуулсан талаар тодорхой мэдээлэл тусгаагүй, хэрэгжилт хангалтгүй, огт хэрэгжээгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.

Цөөхөн газар эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын чанарын хөгжлийн хөтөлбөрт үнэлгээ хийх, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг дүгнэх, нэгдсэн эмнэлэгт гэрээгээр ажиллаж байгаа гал тогоо, хоол үйлдвэрлэл болон харуул хамгаалалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийх зэргээр хяналт үнэлгээ хийснээ тайлагнасан байна.

Хэдийгээр эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын тоо жил тутам нэмэгдэж байгаа ч, бодлогод заасан түншлэлийн тэргүүлэх чиглэлээр өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээнээс бусад чиглэлийн хамтын ажиллагааны уялдаа холбоо бага, үр дүн тодорхой бус байна.

Бүлгийн дүгнэлт

Төр, хувийн хэвшлийн салбарын харилцан ашигтай, урт хугацааны түншлэл бий болгох зорилтын хэрэгжилтийг хувиар авч үзвэл, 34.1% нь маш сайн болон сайн, 13.6% нь хангалтгүй, 52.3% нь огт хэрэгжээгүй байна.

Аймаг нийслэлийн ЭМГ, ЭМСЯ-ны харьяа байгууллагууд нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, олон улсын байгууллага, анагаахын чиглэлийн сургуультай түлхүү түншлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжих боломжтой түншлэлийн төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалтыг гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлэх үйл ажиллагааны хүрээнд шинэ барилга барих, их засвар хийлгэх, тоног төхөөрөмжөөр хангагдах, автопаркийн шинэчлэл хийх, оношилгоо эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэх зэрэг санал, хүсэлт боловсруулан харьяа дээд байгууллагад хүргүүлдэг байна. Харин хэрэгжилт хангалтгүй байгааг дүгнэсэн байна.

Түншлэлийн төслийн зардал, үр ашгийн тооцоо хийх, үр дүнгийн байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд гэрээний нөхцөлийг шинэчлэн сайжруулах талаар хэрэгжилт хангалтгүй, огт хэрэгжээгүй гэж дийлэнх нь үзэж байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын эрүүл мэндийн хувийн хэвшлийн 2621 байгууллагад 15598 ажиллах хүчин ажиллаж байгаагийн 37.0%-ыг үүдэн хувийн эмнэлэг, 35.7%-ыг хувийн эмийн сан эзэлж байна. Нийт ажиллах хүчний 45.6%-ийг хувийн хэвшлийн эмнэлгийн ажилчид эзэлж байна.

Үнэлгээнд 10 аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, ЭМСЯ-ны харьяа 11 байгууллага, нийт 22 байгууллага өөрийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийж, тайлангаа ирүүлсэнийг дүгнэлээ.

Аймаг, нийслэлийн ЭМГ-ын үнэлгээг 4 зорилт бүхий 16 үйл ажиллагаагаар үнэлэхэд, 49.5% нь маш сайн болон сайн хэрэгжиж, 14.3% нь хангалтгүй, 36.4% нь огт хэрэгжээгүй байна.

Эрүүл мэндийн дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт 52.3% нь маш сайн болон сайн, 29.5% нь огт хэрэгжээгүй байна. Энэ зорилтын хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, ЭМД-ын сангаас санхүүжих сонгон шалгаруулалт хийх, жилийн үйл ажиллагааг үнэлэх үедээ төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зохистой байдлын үнэлгээ, хянан зохицуулах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Хувийн хэвшлийн удирдлагын болон дэвшилтэт технологийн ур чадвар, туршлага, ноу хауг нэвтрүүлж, ашиглах зорилтын хэрэгжилт 68.1% нь маш сайн болон сайн, 22.7% нь огт хэрэгжээгүй байна. Энэ зорилтын хүрээнд хувийн хэвшлийн байгууллагатай үзлэг, оношилгоо, эмчилгээ, харуул, хамгаалалт, хог хаягдал, ариутгал, сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажилладаг, эрх зүйн орчин бүрдсэн, хэрэгжилт харьцангуй сайн байна. Ялангуяа өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээг түншлэлийн арга хэлбэрээр гүйцэтгүүлэх үйл ажиллагаа сайн хэрэгжиж байна.

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн бизнесийн зүй тогтлоор хөгжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, өрсөлдөх чадвартай үнийн тогтолцоо бүрдүүлэх зорилтын хэрэгжилт 43.1% нь маш сайн болон сайн, 40.9% нь огт хэрэгжээгүй байна. Энэ зорилтын хүрээнд төрийн байгууллагууд жил бүр удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөндөө эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын удирдлагыг оролцуулан, эрх зүйн шинэчлэл, хөгжлийн чиг хандлага, хамтын ажиллагааны талаар хэлэлцдэг жишиг тогтсон байна. Мөн эрүүл мэндийн хувийн хэвшлийн үйл ажиллагааны статистик мэдээг онлайнгаар сар, улирлаар авдаг, олон нийтэд өөрийн цахим хуудсаар мэдээлэл хүргэдэг байна.

Төр, хувийн хэвшлийн салбарын харилцан ашигтай, урт хугацааны түншлэл бий болгох зорилтын хэрэгжилт 34.1% нь маш сайн болон сайн, 52.3% нь огт хэрэгжээгүй байна. Энэ зорилтын хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, олон улсын байгууллага, анагаахын чиглэлийн сургуультай түншлэн ажиллаж, уулзалт, сургалт хийж, төсөл боловсруулан, холбогдох байгууллагуудад хүргүүлдэг талаар дурдсан байна. Харин түншлэлийн төслийн зардал, үр ашгийн тооцоо хийх, үр дүнгийн байдалд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд гэрээний нөхцөлийг шинэчлэн сайжруулах үйл ажиллагаа огт хэрэгжээгүй үзэж болохоор байна.

Хэрэгжилтийн тайлангаас харахад Дархан-Уул, Төв, Дундговь, Дорнод, Булган НЭМГ, ЭХЭМҮТ-ийн зохион байгуулсан үйл ажиллагаа, арга хэмжээ бусад байгууллагаас харьцангуй сайн байсныг онцлон тэмдэглэж байна.

Байгууллагуудын ирүүлсэн үнэлгээний тайлангаас харахад үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт руу чиглээгүй, бусад ажлыг хамааруулан тайлагнасан, оновчтой бус, давхардсан санаа ихтэй, мөн огт хэрэгжээгүй, ямар нэг санаа, санаачилга гаргаагүй үйл ажиллагаа цөөнгүй байна.

Мөн үйл ажиллагааны төлөвлөгөө нь ЭМСЯ-аас хамаарал ихтэй, ЭМСЯ-ны харьяа байгууллагууд төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар юу хийх нь тодорхой бус, тайлагнахад бэрхшээлтэй байдал ажиглагдлаа.

ЗӨВЛӨМЖ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан орон тооны хүний нөөцийг аймаг, нийслэлийн ЭМГ-т бий болгох, төсөв, цалингийн санг бүрдүүлэхэд бодлогоор дэмжих

Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодлогын хэрэгжилтийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа үйл ажиллагаа, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгах

Төр, хувийн хэвшлийн үүрэг, оролцоог төлөвлөлтөд маш тодорхой тусгах

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгож, эрх зүйн орчныг бүрдүүлэх

Аутсорсингын үйлчилгээнд стратеги төлөвлөлт, тайлагналт, төсөл, хөтөлбөр боловсруулах, баримт бичиг үйлдэх үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судлан, шийдвэрлэх

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, түншлэлийн зөвлөлдөх уулзалтыг улсын хэмжээнд зохион байгуулж, оролцоог нэгдсэн удирдлагаар хангах